

ИРГЭНИЙ НИЙГЭМ БА ИРГЭНИЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: иргэнийн нийгэм, ардчилал, сайн засаглал, иргэний сэтгүүл зүй, сонгогчид, оролцоо

Орчин үеийн глобальчлагдсан дэлхий ертөнцөд төрийн тухай хуучин ойлголт өөрчлөгдөж, түүний гүйцэтгэх үүрэгт ч хувьсал гарчээ. Энэ хувьсал нь эрх мэдлийг дангаараа монопольчлон эдэлж, өөрийн гаргасан хууль дүрмээр иргэдийг захиргаадан дэглэдэг байсан төр эсрэгээр иргэддээ үйлчилдэг, улс орныг удирдахад иргэдийн санаачилга, оролцоог харгалзан үздэг болсон явдлаар тодорхойлогдож байна.

Хамгийн чухал нь төрийн гүйцэтгэж байсан олон үүрэг иргэний нийгмийн байгууллагуудад шилжих үйл явц эрчимжиж байна. Энэ нь олон шалтгаантай юм. Ази, Африк, Латин Америкийн олон оронд төр нь үр бүтээлтэй засаглалыг бүрдүүлэх, иргэний эрх чөлөөг хамгаалах, нийгмийн болон эдийн засгийн хөгжлийг түргэтгэх үүргээ хэрэгжүүлж чадаагүйн улмаас тэдгээр оронд оршин тогтнож байсан коммунист болон цэргийн дэглэмүүд нуран унаж, дэлхийн улс төр, эдийн засгийн орчинд эрс өөрчлөлт гаргасан нь анхдагч шалтгаан мөн. Түүнчилэн эдийн засгийн даяаршлын нөлөөгөөр чөлөөт худалдаа өргөжиж, үндэсний томоохон пүүс, компаниуд хөрөнгө

оруулалтын илүү таатай нөхцөл бүхий улс орнууд руу бизнесээ шилжүүлэх болсноор эдийн засгийг зохицуулах төрийн үүрэг сулрах болов. Бас байгалийн гамшигт үзэгдэл, агаарын бохирдол газар авч, цөлжилт ихсэж, олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг олширч, үндэстэн дамнасан корпорациуд нэг улсаас хамааралгүй ажиллах болсон зэрэг нь төрийн үүрэг оролцоог багасгах дараагийн шалтгаан болж байна.

Өнөө үед глобальчлагдсан бизнес, иргэний нийгэм хоёр төрийн эрх мэдлийг хуваалцах ёстой гэсэн үзэл онол давамгайлах болов. Дэлхийн олон оронд «чадваргүй засгийн газрын хийж барахгүй байгаа гол гол үйлчилгээг иргэний нийгмийнхэн хийж чаддаг»¹ болжээ. Түүгээр ч зогсохгүй эдийн засгийн тоглоомын дүрмийг тогтооход засгийн газар шийдвэр гаргах боломж улам бүр хумигдаж, зах зээлийн эдийн засаг өөрийн дүрмийг тогтоодог болж байна.

Түүнээс гадна ард түмний нэрийн өмнөөс ярьж, шийдвэр гаргах эрх засгийн газарт байгаа эсэхийг иргэний нийгэм үе үе эргэлзэн асууж, хурцаар шүүмжлэх болов. Ийм жишээг бид гаднаас эрэх хэрэггүй. Бэлэн жишээ нь мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудаас “хуудуутай” гэсэн зэмлэл хүлээсэн Оюу толгой, Таван толгойн

гэрээг эргэж харахыг шаардсан иргэний нийгмийн хөдөлгөөнийг нэрлэж болно. Өнөө үед ядуу буурай орнуудын хөгжлийн тусламжийн олон хөтөлбөрийг иргэний нийгмийн байгууллагууд засаг төрөөр дамжуулалгүй хэрэгжүүлэх жишиг тогтсон байна. Тухайлбал төрийн бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байгаа хөгжлийн албан ёсны тусламжийн хөтөлбөрийн хэмжээ НҮБ-ийн ситемийнхээс аль хэдийнээ давжээ.

Тэгвэл өдрөөс өдөрт хүчээ авч, хүрээгээ тэлж байгаа иргэний нийгэм гэдэг чинь чухам юу юм бэ? Олон янзын тодорхойлолт бий. Иргэний нийгмийн тухай ойлголт бүр эрт үед, тухайлбал Цицерогийн бүтээлд томъёологдож байжээ. Сүүлийн хоёр зуу гаруй жилд иргэний нийгмийг тодорхойлох, хэрэгжүүлэх оролдлого тасралтгүй гарч ирсэн юм. Тэд иргэний нийгмийн тухай дараах хоёр тодорхойлолт дээр үндсэндээ нэгдсэн байна. Тэр нь **нэгд**: «Төр засгаас ангид, гэхдээ зэрэгцэн оршдог, өөрсдийн сонирхол хүслийн дагуу нэгдсэн холбоодыг иргэний нийгэм гэнэ», **хоёрт**: «Төр засгийн албан бүтцүүдийн гаднах байгууллагууд болон сүлжээний нийлбэрийг иргэний нийгэм гэнэ» гэсэн тодорхойлолтууд юм.

Иргэний нийгмийн цөм нь төрийн бус байгууллагууд мөн боловч, сонирхлын бүлгүүд, Үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод, соёл урлаг, спорт болон нийгмийн албан бус бусад бүлгүүд энэ ойлголтод багтаж байдаг. Өөр өөр зорилготой, бүр зөрчилтэй байгууллагууд хүртэл энэ ойлголтод багтаж байгааг харж болно. Тэр ч утгаараа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа нь бүгдээрээ нийгмийн эрх ашигт нийцсэн байх албагүй. Тиймээс иргэний нийгмийг зөвхөн өндөр ёс суртахуун бүхий язгуур зорилгын төлөө ажилладаг гэж хатуу ойлгох нь учир дутагдалтай юм.

Иргэний нийгмийн үндсэн үүрэг нь ард иргэддээ ажлаа тайлагнадаг,

хариуцлагын тогтолцоог бүрдүүлж чадсан сайн засаглалыг Засгийн газраасаа шаардах явдал мөн. Иргэний нийгмийн байгууллагууд «Эрх мэдэл, ил тод байдал, иргэний оролцоо болон ардчиллын тухай суурь асуултуудыг байнга асууж, дэвшүүлж байх ёстой»². Ардчиллыг шинээр тогтоож байгаа улс орнуудын эрх баригчид зөв шийдвэр гаргахыг хүсч байгаа ч ардчиллын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхдээ хойрго ханддаг.

Хэрэв энэ дутагдлаа засъя гэвэл тэд гол гол шийдвэрээ иргэдтэй ярилцаж гаргадаг болох ёстой. Ингэх нь засгийн газрыг хүчгүй, өөрийн бодолгүй болгож харагдуулна гэж тэд эмээдэг. Тэгээд иргэний нийгмийг үл сонсож, дураараа шийдвэр гаргадаг. Зарим улс төрчид иргэний нийгмийн байгууллагыг түнш гэхээсээ илүү өрсөлдөгч гэж үзэх нь бий. Энэ нь иргэний нийгэм тодорхой эрх мэдэлтэй болж, нөлөөлөх чадвар, нэр хүнд нь өсч байгаатай холбоотой юм. Тэдний нилээд нь гадаадын зээл тусламжийг хүртэж, тэр хэрээрээ Засгийн газраас улам бүр хамааралгүй болж байгааг ч дурдаж болно.

Иргэний нийгэм засаглалын чанар чансаанд хэрхэн нөлөөлж байгааг улс төр судлаачид сонирхон судалсаар байна. Тэдний зарим нь иргэний нийгмээс ардчиллыг баталгаажуулахад оруулж байгаа хувь нэмрийг онцолж байхад, нөгөө зарим нь сайн засаглалыг хөгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг нь үнэлж байх жишээтэй. Жишээ нь улс төрийн нэрт нийтлэлч Алексис Де Токвилл «АНУ-ын ардчиллын хүч чадал нь гол төлөв хамтын зорилго бүхий иргэдийн мянга мянган төрлийн нийгэмлэг, холбоодын эрч хүч, идэвхтэй үйл ажиллагаанд оршдог»³ гэсэн бол, иргэний оролцоо болон засаглалын хоорондох харилцааг судалсан саяхны нэг судалгааны дүнгээр «Иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байгаа тохиолдолд төр засаг хүчирхэг байж, иргэд нь ч

хууль дүрмээ сайн дагаж мөрддөг»⁴ нь харагдсан байна.

Иргэний нийгмийн хүч чадал нь олон нийтийн эрх ашгийг хамгаалж байгаад оршдог. Хүний эрхийг хамгаалж, байгаль орчин, эрүүл мэнд, боловсролын орчинг сайжруулж, авлигын эсрэг тэмцсэнийх нь төлөө тэдэнд хууль ёсны эрх мэдэл өөрөө ирдэг. Иргэний нийгмийн үйл ажиллагаа хувийн сонирхлыг бус, нийгмийн сонирхлыг эрхэмлэдэг бөгөөд гагцхүү сайн дурын үндсэн дээр явагддаг.

Ийм ариун зорилготой, ирээдүйтэй, хүчтэй үйл хэрэг монголд аль хэр явцтай байна, нийгэмд яаж нөлөөлж байна вэ? Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэний дараах жилүүдэд төрийн бус байгууллагууд шил даран гарч ирсэн. Өнгөрсөн жилүүдэд ийм байгууллагын тоо дөрвөн мянга хол давсан юм. Тэдний нийгэмд гүйцэтгэж байгаа үүргийг үгүйсгах аргагүй боловч бас хангалттай гэж хэлэхэд бэрх. Манай иргэний нийгмийн байгууллагуудын сул талыг дараах хоёр үндсэн дутагдлаар тайлбарлаж болно.

Юуны өмнө зорилго нь буруу. Нийгмийн сайн сайхны төлөө гэхээсээ илүү ямар нэг аргаар хуулийн этгээд болж, гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах, хандив тусламж авах зэргээр амиа борлуулж явдаг төрийн бус байгууллага олон байгаа нь нууц биш. Тэдний олонх нь ардчиллыг хөгжүүлэх, шударга ёс тогтоох, хүний эрхийг хамгаалах, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих гэхчилэн чихэнд чимэгтэй нэр хаяг зүүдэг боловч, хэрэг дээрээ хувийн сонирхол нь давамгайлж байдаг. Нөгөө нэг дутагдал нь ажлын үр дүнтэй арга барилыг сонгож чадахгүй байх явдал. Бидний анхаарал энэ бүлгийн байгууллагуудад хандах ёстой.

«Чи хичнээн уран илтгэгч байлаа ч долоон уулын цаана дуулдтал хашгирч чадахгүй» гэсэн үг бий. Юу гэх гээд байна гэвэл үнэхээр ажил хийх гэж оролдож байгаа иргэний нийгмийн

байгууллагууд байвал дуу хоолойгоо ард түмэндээ хүргэдэг болооч гэх гэсэн юм. Ингэхийн тулд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай сайн түншийн харилцаа тогтоогооч, өөрсдөө олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлээч гэж хэлэх гэсэн юм. Тодруулж хэлбэл иргэний сэтгүүл зүйд суралцахыг үриалсан юм.

Ингэхийн тулд иргэний сэтгүүл зүй гэдэг чухам юу юм бэ, түүнийг яаж хийдэг юм бэ? гэсэн асуултанд хариулах хэрэгтэй болно. Иргэний сэтгүүл зүй нь юуны өмнө амьдралдаа тохиолдсон чухал асуудлыг мэдээлэхэд идэвхтэй оролцдог сонгогчдын сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм. Сэтгүүл зүйн энэ шинэ төрөл үүсэх уг шалтгаан нь нэг талаас иргэдийн дотор улс төрийн бодлогыг сонирхох хэмжээ буурч, улс нийгэм, оршин суугаа орчныхоо хөгжил цэцэглэлтэд санаа тавих нь багасч, нөгөө талд хайхрамжгүй, сонор сэрэмжгүй иргэдийн сул талыг ашиглаж эрх баригчид дур зоргоороо авирлаж, товчоор хэлбэл нийгэм ихээхэн урсгал байдалтай болсон явдал мөн.

Нөхцөл байдал ийм байхад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дэлхий дахины болон өөрийн орны улс төрийн үйл явдал, нэр цуутай хүмүүсийг тойрсон адал явдлуудад гол анхаарлаа хандуулж, жирийн иргэдийн амьдралд хуримтлагдсан хурц асуудлууд ямар нэг хэмжээгээр орхигдох болсон байна. Энэ бүхнээс үүдэн сэтгүүл зүйг жирийн иргэдийн амьдрал ахуйд ойртуулж, улам бүр олон нийтийн шинжтэй болгох шаардлага тулгарсан нь иргэний сэтгүүл зүй үүсэх шалтгаан болсон гэж судлаачид үзэж байна.

Орчин үед сэтгүүл зүйн нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх асуудал хурцаар тавигдаж байгаа нь ч дээрх шалтгаантай холбоотой юм. Өнөөдөр дэлхий дахины сэтгүүлч, судлаачдын олонх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн өмнө өндөр хариуцлага хүлээх ёстой гэсэн онолд нэгдэж

байна. Нийгмийн хариуцлагын онолын нэг чухал чиглэл нь сэтгүүл зүйн үйл ажиллагаанд олон нийтийг идэвхтэй оролцуулах замаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний ажилтнуудад хариуцлагыг нь ухамсарлуулах явдал ажээ. Америкийн иргэний сэтгүүл зүйн нэрт төлөөлөгч Жон Дев «Нийгэмд хариуцлага хүлээх ёстой сэтгүүл зүй харин хариуцлагаас мултрах үүрэг хүлээх болов.

Нийгмийн хариуцлагын онолчид ардчилал нь зөрчил бүхий мэдээлэл дээр тулгуурласан дуулгаваргүй, ёс суртахуунгүй хэвлэл мэдээллийн заналхийлэлд автаж байна. Иймээс эрүүл саруул нийгэм байгуулахад туслах харилцааны чухал хэлбэр болсон иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэх хэрэгтэй хэмээн үзэж байна. Ингэснээр сэтгүүлчид ардчилсан засгийн газрыг зөвхөн хянах төдий бус, түүний үйл ажиллагаанд оролцогч байх ёстойн нэг адил, иргэд ч сэтгүүл зүйн идэвхгүй хүлээн авагчид бус, түүний үйл ажиллагаанд оролцогч байх ёстой ажээ. Иргэдийг ийнхүү оролцоход нь туслах гол хүч нь иргэний нийгмийн байгууллага байх бүрэн боломжтой юм. Ингэснээр тэд өөрсдийнхөө ажлыг ч давхар хийж байна гэж ойлгох учиртай юм.

Иргэний сэтгүүл зүй нь нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээс амьдралын гүн лүү тавих анхаарлаа нэмэгдүүлж, жирийн иргэдийн ахуй амьдралыг илүү тусгах үйл ажиллагаа, нөгөө талаас хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр татан оролцуулж, тэднээс ахуй амьдралынхаа тулгамдсан асуудлыг сөхөн тавьж, шийдвэрлэхэд нь мэдээллийн

хэрэгсэл, сэтгүүлчид туслах явдал юм. Энэ шаардлагын дагуу олон нийтийн хэвлэлүүд, ялангуяа нийтлэлийн бодлогоороо олон нийттэй хүчтэй холбогдог сонинуудын үйл ажиллагаанд нийгмийн идэвхтэй хэсэг түлхүү оролцож, иргэний чухал асуудлыг мэдээлэх болсноор иргэний сэтгүүл зүй үүссэн байна.

Иргэний сэтгүүл зүй нь интерактив сэтгүүл зүйн нэг хэлбэр бөгөөд амьдралын өөр өөр төвшний хүмүүсийг сонин сэтгүүлд өгүүлэл материал бичүүлэх, амьдралаас олж илрүүлсэн зүйлээ мэдээлэхэд өргөнөөр татан оролцуулдаг сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм. Америкийн сэтгүүлч эрдэмтэд иргэний сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, нөлөөлөх чадварыг олонтаа тодорхойлсны дотор эрдэмтэн Гунаратне сэтгүүл зүйн энэ төрлийн өөр өөр шинж чанарыг илэрхийлсэн гурван янзын тодор-

хойлолт гаргасан байна. Тэрбээр *нэгдүгээрт*: энгийн иргэдийн дотроос идэвхтэй хэсгийг нэгтгэх замаар олон нийтийн ухамсарт хүч нэмж, зоригжуулахад сэтгүүл зүйг чиглүүлэх хөдөлгөөн мөн, *хоёрдугаарт*: Олон нийтийн анхаарал татсан асуудлыг хэлэлцэхэд өөрийн ухамсраар оролцож, дуу хоолойгоо илэрхийлэх идэвх бүхий олон нийтийг буй болгох хөдөлгөөн, *гуравдугаарт*: Нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээх үйл явцыг илүү эрчимтэй болгон олон нийтэд хүрч ажиллах, нөгөө талаас иргэд тулгарсан асуудлууддаа хэрхэн хандаж байгаа хийгээд түүнийг шийдвэрлэх арга замыг хэрхэн эрж хайж байгааг тодорхойлох оролдлого гэсэн байна.

«

Иргэний сэтгүүл зүй нь интерактив сэтгүүл зүйн нэг хэлбэр бөгөөд амьдралын өөр өөр төвшний хүмүүсийг сонин сэтгүүлд өгүүлэл материал бичүүлэх, амьдралаас олж илрүүлсэн зүйлээ мэдээлэхэд өргөнөөр татан оролцуулдаг сэтгүүл зүйн үйл ажиллагаа юм.

»

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд сонин сэтгүүл, мэдээллийн бусад хэрэгслүүд иргэний асуудлаар цуврал өгүүлэл, хэлэлцүүлэг нийтэлж, сэдэвчилсэн нэвтрүүлэг бэлтгэж, тэдгээртээ орон нутаг, тэндхийн хүмүүс, хэсэг бүлгүүдийн тулгамдсан асуудлыг сурвалжлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг санал болгодог. Иргэний сэтгүүл зүйн өөр нэг хэлбэр нь улс төрийн компанит ажил, эсвэл төсөв хэлэлцэх гэх мэт хэл ам дагуулсан том үйл явдлын үеэр цугларч, өөр өөр ойлголтой хүмүүс үзэл бодлоо солилцдог иргэдийн янз бүрийн төвшний хурал юм. Хөгжил дэвшлийн төлөө тэдний хийж буй ажил, гаргаж байгаа саналыг хэвлэл мэдээллээр дамжуулан цацдаг. Заримдаа улс орон даяар болж буй чухал үйл явдлын талаар олон нийтийн санал асуулга ч явуулдаг. Энэ арга ялангуяа тогтмол хэвлэлүүдэд уламжлал болсон юм. Түүнчилэн хэвлэлүүд өөр өөр бодолтой хүмүүсийг урьж ирүүлэн «Дугуй ширээ»-ний ярилцлага хийж тэдний үзэл бодлын ялгааг тогтоох, зарим нийтлэг учир шалтгааныг илрүүлэх оролдлого хийж, түүнийгээ хэвлэлээр мэдээлдэг туршлага бий.

Иргэний сэтгүүл зүйн сэдэв маш өргөн хүрээг хамардаг. Тэдгээрийн дотроос хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, агаарын бохирдол, цөлжилт, дэлхийн дулаарал, байгалийн гамшигт үзэгдлээс иргэдэд учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг багасгах, нийгэмд шударга ёс тогтоож, ардчиллын зарчмыг хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх, жирийн иргэд, эмзэг бүлгийнхэнд тулгарч байгаа амьдралын бэрхшээлийг хөнгөлөх зэрэг асуудлаар төр засагт шахалт, шаардлага тавьсан бүх нийтлэл хийгээд үйл ажиллагаанд голлон анхаардаг.

Энэ бүхэн бол иргэний нийгмийн байгууллагын анхаарлын төвд байх ёстой асуудлууд юм. Эдгээр асуудлын хувьд иргэний сэтгүүл зүй, иргэний нийгмийн байгууллага хоёрын зорилго,

эрх ашиг нэгдэж байдаг. Өөр үгээр хэлбэл иргэний сэтгүүл зүй бол иргэний нийгмийн байгууллагын хүчтэй зэвсэг мөн. Харамсалтай нь манай төрийн бус байгууллагууд энэ зэвсгийг ашиглаж чадахгүй байгаа юм.

Иргэний сэтгүүл зүйн нөгөө нэг тал нь иргэд, олон нийт өөрсдөө сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх явдал мөн. Тэр нь хамгийн энгийн зүйлээс эхэлдэг. Тухайлбал иргэдийн тодорхой хэсэг өөрсдийн аж төрж байгаа хороо хорины нутаг дэвсгэрийг хоггүй орчин болгох талаар зөвлөн ярилцаж, гаргасан санал санаачилгаа дүүргийн эрх баригчдад тавих юм уу, эсвэл сонин хэвлэлд хандаж болно. Тойргоосоо сонгогдсон Их хурлын гишүүн өөрсдийг нь хэрхэн төлөөлж байгааг дүгнэн хэлэлцэж, ирэх сонгуульд хэнийг дэмжихээ харилцан ярилцсан ч иргэний сэтгүүл зүй болно. Манай иргэний байгууллагууд онцгой үед ганц нэг удаа сүртэй мэдэгдэл хийж “амьд” байгаагаа мэдэгдчихээд бусад үед нь хувь хувиа харан таг чиг болцгоодог.

Иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллээр сурталчилж, гэгээрүүлэх үйлсэд голлон анхаарахгүйгээр амжилт олж чадахгүй. Ийнхүү хүчирхэг дуу хоолойтой байхын тулд өөрийн гэсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болох нь чухал. Ингэхийн тулд хамтрах, хорших зэргээр хүч, хөрөнгөө нэгтгэх хэрэгтэй. Өнөөдөр иргэдэд тулгарсан асуудлыг дагнан тусгадаг мэдээллийн хэрэгсэл нэг ч алга. Менежментийн үүднээс аваад үзсэн ч энд сонинны бизнесийн зохих орон зай байгаа нь харагддаг. Учир нь уншигчдад улс төр, цаг үеийн үйл явдал, олон улсын амьдралаас дутуугүй хүнд бэрх амьдрал туулж, зовж зүдэрч яваа хүний намтар түүх сонин байдаг. Ганц жишээ татъя. «25 суваг» телевиз «Танайд хоноё» гэдэг нэвтрүүлгийн хэдэн арван дугаар бэлтгэсэн. Гэтэл тэдгээрийн дотроос хүнд өвчинд

нэрвэгдэж үхэл, амьдралын зааг дээр очсон атлаа зориг хатуужлын жишээг үзүүлж амьдрахын төлөө тэмцэж яваа, хоёр нялх хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэй Тунгалагийн тухай нэвтрүүлэг үзэгчдийн сэтгэлд хамгийн их хүрч, өнөөдөр ч мартагдаагүй байна. Үзэгч, уншигч, сонсогчдод амьдралын учир утгыг ойлгуулах, тууштай, тэсвэртэй зан чанарыг төлөвшүүлэхэд ийм нийтлэл, нэвтрүүлгийн ач холбогдол их юм. Тэр чинээгээрээ эрэлт хэрэгцээ ч байгаа нь тодорхой. Гараараа хийдэг ажил байхад амаараа хийдэг ажил бас байдаг. Иргэний байгууллагууд байшин барьж, уурхай малтахгүй нь мэдээж. Харин иргэдэд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлыг төр засагт байнга сануулж, шийдвэрлэх арга замыг санал болгож чадвал үүргээ биелүүлж байгаа хэрэг. Тэр бүхнийг шийдвэр гаргагчид хийгээд олон нийтэд хүртээмжтэй хүргэдэг хүчирхэг индэр нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

Иргэний сэтгүүл зүй нь иргэний нийгмийн байгууллагын ажлын хөдөлгөч хүч мөн. Нийгмийн хурц, тулгамдсан асуудлуудыг сөхөн тавьж, түүнийг шийдвэрлэхийн тулд нэг талаар эрх баригчдын чихэнд байнга "хонх зүүж", нөгөө талаар ард иргэдийн сэтгэлд хоногшуулж байх нь иргэний нийгмийн байгууллагын зорилт юм.

Ишлэл

¹ *Jessica T.* 1997. Power shift, *Foreign Affairs*, p. 315.

² *Origo C.* 1995. Citizen Participation and the Strengthening of Accountability in Chile's Municipal Governments.

³ *Toquill A. D.* Citing Democracy in America. Wadsworth, p. 513-514.

⁴ *Putnam R. D.* Making Democracy Work. McMillan, p. 89.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Baran S. J., Davis D. K.* 1999. Mass Communication Theory. Wadsworth.

2. 1998. Don't Stop There! Five Adventures in Civic Journalism. Washington.

3. *Stuart A.* 2001. Media & Ethics. Volume 6. Number 1.

4. *Thorson E.* 1996. Civic Lessons. Madison.

5. *Норовсүрэн Л.* 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.

6. *Норовсүрэн Л., Энхтуяа Х.* 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ.

7. *Цэрэндагва Д.* 1983. Сонин хамтын зохион байгуулагч. УБ.

8. *Горохов В. М.* 1975. Закономерности публицистического творчества. М.

9. *Лазутина Г. В.* 1999. Профессиональная этика журналистика. М.

Summary

The article covers the beginning and development of civil journalism and its genres. It has responded some important issues concerning whether there's a tradition of journalism in Mongolian literature and whether journalism movement of workers and herders belong to civil journalism. It has put forward proposal to use civil journalism as a weapon of civil organizations and proposed ways to implementation.